

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ШИНЭ МУЗЕЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нийтлэг үндэслэл, хэрэгцээ шаардлага

Дархан хотод МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга нарын 1970 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 553-р тогтоолоор Дархан хотын Музейн үндэс суурь тавигдсан. МАХН-ын 1972 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн Төв хорооны тогтоолоор В.И.Лениний мэндэлсний 100 жилийн ойгоор Монгол—Зөвлөлтийн найрамдал, ах дүү социалист орнуудын тухайн цаг үеийн хамтын ажиллагааг харуулсан 4 танхимтай “Найрамдал” музейг гэрэл зураг зонхилсон 500 гаруй үзмэртэйгээр олон нийтэд анх удаа дэлгэн үзүүлж, албан ёсоор нээсэн. В.И.Ленин, Д.Сүхбаатарын үйл амьдрал, Монгол-Зөвлөлтийн найрамдал, ах дүү социалист орнуудын хамтын ажиллагаа, хотын өнгөрсөн, одоо, ирээдүйг харуулсан 3 танхимтай. 1991 онд Соёлын Яамны шийдвэрээр Дархан хотын “Найрамдал” Музейг Дархан хотын Түүхчилсэн Музей болгон шинэчлэн зохион байгуулах Дархан хотын АДХГЗ-ны тогтоолоор Түүх-Аж үйлдвэрийн, Угсаатан, Байгалийн гэсэн 3 танхимтай Дархан хотын музей нэртэйгээр шинэчлэгдэж, УИХ-ын 1994 оны 32-р тогтоолоор МУ-ын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу Дархан хотыг Дархан Уул аймаг болгон өөрчилсөн бөгөөд үүний дагуу “Дархан Уул аймгийн Музей” болж өргөжин шинэчлэгдсэн. Байгаль, түүх, угсаатан, олон улсын харилцаа, найрамдал хамтын ажиллагаа, аж үйлдвэржилт сэдвээр үзүүллэгээ дэглэн боловсрол, танин мэдэхүйн үйл ажиллагаагаар сурталчлан таниулдаг.

Музейн тухай хуулийн 4.1.2 дахь заалтад заасанчлан музейн үзэл баримтлал нь музейн төрөл, үйл ажиллагааны чиглэл, хамрах хүрээ, цуглуулгын болон үзүүллэгийн бодлогыг тодорхойлсон баримт бичиг болохын хувьд Дархан-Уул аймгийн музейн шинэ барилгатай холбоотой музейн одоогийн үйл ажиллагаа, цуглуулгын бодлогод үнэлгээ хийн музейн шинэ үзэл баримтлалын үндсэн чиглэлийг аймгийн нийгэм, эдийн засаг, соёлын хэтийн хөгжлийн төлөвлөлттэй уялдуулан, ард иргэдийн хүсэл сонирхлыг харгалзсан, түүх, соёл, угсаатан, урлаг уран сайхны үнэ цэн бүхий онцлог, шинжлэх ухааны үндэслэлтэй музейн үзэл баримтлалын үндсэн чиглэлийг ахин шинээр тодорхойлох хэрэгцээ шаардлагын хүрээнд боловсруулав.

Үзэл баримтлалын зорилго

Дархан-Уул аймгийн музейн цаашдын хөгжлийн чиг хандлага, үйл ажиллагааны үндсэн чиглэл, хамрах хүрээ, сан хөмрөгийн цуглуулгын баяжилт, үзүүллэг дэглэлтийн бодлогыг бүс нутгийн хөгжлийн түвшинд тодорхойлоход оршино.

Музейн үйл ажиллагааны чиглэлийг өргөжүүлж бүс нутагтаа тэргүүлэх түвшний Түүх, угсаатан, олон соёлын музей болгох зорилтын хүрээнд Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, Олон улсын музейн зөвлөл (ICOM)-ийн ёс зүйн дүрмийг баримтлан энэхүү үзэл баримтлалыг боловсруулав.

Музейн төрөл

Дархан-Уул аймгийн музей нь тухайн орон нутгийн түүх, угсаатны соёлын ондоошлыг илэрхийлсэн, олон соёлын хэв маягийг бүрдүүлсэн сан хөмрөгийн цуглуулгын бодлогыг тодорхойлж, үзүүлэлэг дэглэлтэд тусган, боловсрол олон нийтийн хөтөлбөрөөр олны хүртээл болгон, орон нутгийн ард иргэдийн олон соёлын харилцааг хүндэтгэн соёлын дархлааг бий болгох, нийгэм, соёл, байгаль орчин, эдийн засгийн хөгжилд үнэ цэнтэй байх Түүх, Угсаатан, Олон соёлын нэгдмэл түүх, угсаатны төрлийн музей байна.

Алсын хараа

Бүс нутгийн нийгэм, эдийн засаг, соёлын олон талт тогтвортой хөгжилд нөлөөлөхүйц соёлын хүртээмжтэй үйлчилгээтэй музейн загварыг бий болгоно.

Эрхэм зорилго

Соёлын үнэт зүйлийг хадгалж хамгаалан, хойч үедээ уламжлуулж иргэдийн оюуны тодорхой эрэлт, хэрэгцээг хангах, улмаар нийгмийн хөгжилд үр нөлөө үзүүлэхэд оршино.

Музейн үйл ажиллагааны үндсэн чиглэл

Музей нь үзэл баримтлалын хүрээнд Музейн тухай хуулийн 7 дугаар зүйлийг үндэс болгон дараах үйл ажиллагааг эрхэлнэ.

- Түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах, байгаль, нийгэм, түүх, соёл урлаг, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол бүхий өвийг эрэн сурвалжлах, нээж илрүүлэх, цуглуулах;
- Аймаг, Бүс нутгийн соёлын үнэт зүйлийг бүртгэн баримтжуулж, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх;
- Музей судлалын шинжлэх ухааны үндэслэлтэй үйл ажиллагаа эрхлэх;
- Дархан-Уул аймгийн нэн эртний түүхэд холбогдох археологийн цуглуулгыг цуглуулах, хадгалах, эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах;
- Эрдэм шинжилгээ судалгааны эрхлэх;
- Үзүүлэлэг дэглэх, соёлын хүртээмжтэй, нийгмийн тэгш бус байдлыг бууруулах олон талт үйлчилгээг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх;

- Дотоод, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, үзэсгэлэн зохион байгуулах;
- Чанартай боловсролыг дэмжих, бүх насны боловсролын олон талт хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
- Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих, танин мэдэхүйн сургалт, арга хэмжээг зохион байгуулах;
- Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, олон соёлын гүүр болох;
- Хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа.

Хамрах хүрээ

Үйл ажиллагааны хүрээнд гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, их дээд сургууль, хувийн хэвшил, аж ахуйн нэгж, олон улсын байгууллага, иргэд;

Цуглуулгын хүрээнд аймаг, бүс нутгийн түүх, археологи, угсаатны соёлын үнэт зүйл, баримтат өв

Цуглуулгын бодлого

Цуглуулгын хүрээнд аймаг, бүс нутгийн түүх, угсаатан, археологи, урлаг уран сайханд холбогдох соёлын үнэт зүйлийн судалгаа, шинжилгээ, танин мэдэхүй, өвлөн уламжлуулах зорилгоор бүрдүүлэх. Сан хөмрөгийн хүрээнд системтэй, цогц, иж бүрдэл, шинжлэх ухааны үндэслэлтэй цуглуулгаар төрөлжүүлэн, баяжуулна. Үүнд:

Түүхийн холбогдолтой цуглуулгын сан хөмрөгт:

- Дархан хот, Дархан-Уул аймгийн түүхэн он цагийн бодит гэрч болох түүхийн ач холбогдол бүхий соёлын биет болон биет бус өв, баримтат өв;
- Шинжлэх ухаан, техник технологид холбогдох эд өлөг;
- Хотын соёл, архитектурт холбогдох эд өлөг;
- Улсын хөгжлийн бүхий л он цагийн үед өндөр технологи ашиглан хийсэн соёлын болон үйлдвэрлэлийн үнэ цэн бүхий эд өлөг;
- Улсын аж үлдвэрийн түүхэнд чухал хувь нэмэр оруулсан бүтээгдэхүүн;
- Бусад

Угсаатны зүйд холбогдолтой цуглуулгын сан хөмрөгт:

- Аймаг, бүс нутгийн нутаг дэвсгэрт зэрэгцэн орших угсаатны бүлгүүд, тэдгээрийн ахуй амьдралд, дээл хувцас гоёл чимэглэл, газар тариалан, тоглоом наадгайд холбогдох соёлын үнэт зүйл, эд өлөг

Археологийн дурсгалд холбогдох цуглуулгын сан хөмрөгт:

- Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрээс олдсон археологийн дурсгал болох чулуун зэвсэг, гоёл чимэглэлийн эд зүйл, ахуйн хэрэглээний эд зүйл, хувцас хэрэглэл, зэр зэвсэг, байлдааны хэрэгсэл, шүтлэг зан үйлийн холбогдолтой эд зүйл, эртний хот суурингын холбогдолтой эд зүйл, чулуун дурсгал, булш оршуулгын дурсгал, тахил тайлгын байгууламж, барилга архитектурын дурсгал, үйлдвэрлэлийн ул мөр хадгалсан дурсгал, хаднаах зураг бичгийн дурсгал

Урлаг, уран сайханд холбогдох цуглуулгын сан хөмрөгт:

- Дархан хот, бүтээн байгуулалтын тухай уран зураг, зэс хөөмөл, баримал, алдартны хөрөг зураг, баримал

Үзүүлэгийн бодлого

Музейн байнгын үзүүлэлэг нь аймгийн Засаг дарга соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн баталсан үзүүлэлэг дэглэлтийн төлөвлөгөөний хүрээнд дэглэгдэнэ. Аймгийн шинэ музейн үзүүлэлэг дэглэлтийн төлөвлөгөөг хуульд заасны дагуу боловсруулж, шинэчлэн сайжруулж ажиллана.

Үзүүлэлэг дэглэлтийн уран сайхныг музейн онол, арга зүй, соёлын өвийн хадгалалт хамгаалалтын шинжлэх ухааны судалгаа, шинжилгээ, дүрслэх урлаг ба дизайны онол, зохиомжийн шийдэл зэргийн зүй зохист харьцаан дээр үндэслэн, одоогийн болон ирээдүйн үзэгч, үйлчлүүлэгчдийн хэрэгцээ, шаардлагыг хангахуйц үзүүлэлэг дэглэлттэй байна. Музейн үзүүлэлэг дэглэлтийн уран сайхны онцлог нь үзэгчийн явах чиглэлд суурилж, бага орон зайд цаг хугацааны олон үйл явдлыг **СЭДЭВЧИЛСЭН** байдлаар гүйцэтгэгдэнэ.

Дархан-Уул аймгийн шинэ музейн үзэл баримтлал, үзүүлэлэг дэглэлтийн ажлын хэсгийн зүгээс музейн үзэл баримтлал, үзүүлэлэг дэглэлтийн судалгааны үндсэн дээр танхимын зохион байгуулалтыг дараах байдлаар гаргалаа. Үүнд, аймгийн шинэ музейн зоорийн давхрын танхимыг түр үзэсгэлэнгийн танхим, 1-р давхарт “Сургалт мэдээлэл” мини театр, “Хүндэтгэл”-ийн танхим, 2-р давхарт “Найрамдал” танхим, 3-р давхарт “Илгээлтийн эзэд”, “Олон соёл”, “Урлаг” танхимууд тус тус байрлана.

Түр үзэсгэлэнгийн танхим:

- Түр үзэсгэлэнгийн танхим нь шинэ музейн барилгын зоорийн давхарт байрлаж, нийт 146,1 м² талбайг эзлэн оршино. Танхимаар тодорхой сэдэвт үзэсгэлэнгүүдийг зохион байгуулж ард иргэдэд соён гэгээрлийн ажлыг түгээн дэлгэрүүлнэ.

“ХҮНДЭТГЭЛ” танхим, “Сургалт мэдээлэл” мини театр:

- Хүндэтгэлийн танхим нь шинэ музейн барилгын 1-р давхарт байрлаж, нийт 126,0 м² талбайг эзлэн оршино. Танхиын эхний хэсгээр Дархан хот, Дархан-Уул аймгийн бэлэг тэмдэг, бэлэгдэл амьтан, сүлд дуу, аймгийн хүндлэн дээдэлдэг урлагийн бүтээл, эд зүйлийг дэлгэн харуулна. Танхимын хоёрдугаар хэсгээр Дархан-Уул аймгийн үүсэл, түүхэн домог, аман яриа, түүхийн эртний ул мөрийг гэрчилсэн археологийн эд өлгийн зүйлийг дэглэнэ.
- Сургалт мэдээллийн мини театр нь Хүндэтгэлийн танхим нь шинэ музейн барилгын 1-р давхарт байрлаж, нийт 51,8 м² талбайг эзлэн оршино. Танхимаар Дархан-Уул аймгийн үүсэл, хөгжил, бүтээн байгуулалт, бэлэг тэмдэг, хүндлэн дээдлэх зүйлийг контент хэлбэрээр үзүүлнэ. Мөн музейн тухай нэгдсэн танилцуулгыг энэ танхимаас авна.

“НАЙРАМДАЛ” танхим:

- Найрамдал танхим нь шинэ музейн барилгын 2-р давхарт байрлаж, нийт 223,4 м² талбайг эзлэн оршино. Танхимаар Дархан хотын суурийг анх тавьсан үеэс эхлэн үйлдвэр, завод, орон сууцны хороолол, соёл, урлаг болон дэд бүтцийн бүтээн байгуулалтыг харуулсан фото зураг, уран зургууд, Монгол-Зөвлөлт, олон улсын хамтын ажиллагаа, найрамдлын түүхийг дүрслэн харуулсан эд өлгийн зүйл, фото зураг, уран зураг, уран баримтал зэргийг дэлгэн харуулна.

“ИЛГЭЭЛТИЙН ЭЗЭД” танхим:

- Энэхүү танхим нь шинэ музейн барилгын 3-р давхарт байрлаж, нийт хоёр өрөө буюу 164,1 м² талбайг эзлэн оршино. БНМАУ-ын өнцөг булан бүрээс ирсэн илгээлтийн эздийн түүх, намтар, биет өв, аман түүх, тэдгээртэй холбоотой урлагийн бүтээл, фото зургийг дэлгэн харуулна.

“ОЛОН СОЁЛ” танхим:

- Танхим нь музейн 3-р давхарт байрлаж, нийт гурван өрөө буюу 718,4 м² талбайг эзлэн оршино. Тус танхимаар Монголын олон ястны эдийн соёл, эд өлгийн зүйл, биет бус өвийн хамтаар дэглэж үзүүлнэ. Эхний өрөөгөөр шашны эдлэл хэрэглэлийг үзэл баримтлал, үзүүллэгийн концепцийн дагуу дэглэнэ.

“УРЛАГ” танхим:

- Танхим нь музейн 3-р давхарт байрлаж, нийт гурван өрөө буюу 72,8 м² талбайг эзлэн оршино. Урлаг танхим нь Дархан-Уул аймгийн

дүрслэх урлаг, тайз, дэлгэц болон кино урлаг бүтээлийг сурталчлах, шинэ бүтээлийг үзэгчдэд танилцуулах агуулгатай байна.

Дархан-Уул аймгийн музейн зохион байгуулалтын бүтэц

Зохион байгуулалтын бүтцийн хувьд Захиргаа аж ахуйн хэлтэс, Сан хөмрөг, Бүртгэл мэдээллийн хэлтэс, Эрдэм шинжилгээ, арга зүйн хэлтэс, Боловсрол, маркетингийн хэлтэс гэсэн зохион байгуулалттай нийт 35 хүний бүрэлдэхүүнтэй байна.

Захиргаа аж ахуйн хэлтэс нь байгууллагын аж ахуй, хүний нөөц, аюулгүй байдал, харуул хамгаалалт, үзэгчдийн үйлчилгээ, музейн өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулж, хяналт тавина. Хэлтсийн дарга- 1 хүний нөөцийн ажилтан- 1, зохион байгуулагч-1, аюулгүй байдал, мэдээлэл технологийн ажилтан-1, үзмэр харгалзагч-6, үйлчлэгч-3, мужаан-1, сантехникч- 1, цахилгаанчин-1, харуул хамгаалалт- 4 нийт 20 хүний бүрэлдэхүүнтэй.

Сан хөмрөгийн хэлтэс цуглуулгын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг стандартын хүрээнд ханган ажиллана. Хэлтсийн дарга- 1, сан хөмрөгч- 2, нийт 4 хүний бүрэлдэхүүнтэй.

Бүртгэл мэдээллийн хэлтэс нь цуглуулгыг бүртгэн баримтжуулж, мэдээллийн сан бүрдүүлэн, цуглуулгын хөдөлгөөн, лавлагаа мэдээллийг хариуцан, музейн сан хөмрөгийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана. Хэлтсийн дарга- 1, бүртгэл мэдээллийн санч- 1, баримтжуулалтын ажилтан- 1 нийт 3 хүний бүрэлдэхүүнтэй.

Эрдэм шинжилгээ, арга зүйн хэлтэс нь сан хөмрөгийн цуглуулгын бодлогыг тодорхойлох, боловсруулах, цуглуулгыг эрдэм шинжилгээ, судалгааны эргэлтэд оруулах, судлах, бүтээл хэвлүүлэх, үзүүлэлэг дэглэлтээр дамжуулан олон нийтэд үнэн зөв, шинжлэх ухааны мэдээ, мэдээллийг, түгээх арга зүй, материал, үзмэрийн тайлбарыг боловсруулах, хэрэгжүүлэх, дэглэлтэд ашиглах, дотоод гадаадын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагатай хамтарсан, бие даасан хайгуул, судалгааны ажил эрхлэх, үр дүнг олон нийтэд түгээх, сан хөмрөгийг баяжуулах ажлыг гүйцэтгэнэ. Хэлтсийн дарга- 1 (Доктор Ph.D), эрдэм шинжилгээний ажилтан-3 (түүхч, угсаатны зүйч, антропологич, археологич, урлаг судлаач), арга зүйч -1 (музей, соёл судлаач), үзүүлэлийн куратор- 1, сэлбэн засагч- 1 нийт 7 хүний бүрэлдэхүүнтэй.

Боловсрол, маркетингийн хэлтэс нь музейн үйлчилгээг олон нийтэд хүртээмжтэй хүргэх, үйл ажиллагааг сурталчлах гадаад харилцаа, маркетингийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хүүхэд залуус, иргэдийг соён гэгээрүүлэх, бүх насны музейн боловсролын ажил, албан бус сургалтын хөтөлбөр, музейн үйл ажиллагааг сурталчлан ажиллана. Хэлтсийн дарга- 1 (Гадаад харилцааг хариуцаж болно), маркетингийн менежер- 1,

олон нийттэй харилцах ажилтан- 1, боловсролын ажилтан- 2 нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй.

Нийгэм эдийн засгийн ач холбогдол

Аймаг, бүс нутгийн нийгэм, эдийн засаг, соёлын хөгжилд үр нөлөө үзүүлж, нутгийн ард иргэдийн сайн сайхан аж байдалд эергээр нөлөөлнө;

Дархан-Уул аймаг соёлын аялал жуулчлалын таатай бүс нутаг болоход дэмжлэг үзүүлэн, орлогыг нэмэгдүүлэн эдийн засгийн үр өгөөж дээшилнэ;

Соёлын бүтээлч үйлдвэрлэл, кино үйлдвэрлэлийг дэмжих, хэрэгжүүлэх төв болно;

Дархан хот Төвийн бүс тулгуур төв болоход эдийн засаг, нийгэм, соёлын ач холбогдолтой;